



## Галтай Зуух

**МАГТААЛ ХҮНДЛЭЛ** Бид Их Эзэнийг магтан хүндлэхдээ баяртай байдаг.

### Унших Зүйл

Даниел 3; *Зөнчид ба Хаад*, х. 503-513.

### Цээжлэх Ишлэл

"Бид Их Эзэнд үйлчлэх болно" (Иошуа 24:15).

### Зорилго

#### Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Зөвхөн Их Эзэн л тэдний магтаалыг хүлээн авдаг гэдгийг **мэдэх** болно.

Их Эзэний үгийг **дагах** болно.

Дуулгавартайгаар Их Эзэнийг **магтан хүндлэх** болно.

### Гол Санаа



Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.

## Хичээлээ Бэлтгэх нь

### Библийн Хичээлийн Товчлол

Небухаднезар хааны бариулсан алтан хөшөөнд Даниелын гурван найз мөргөдөггүй бөгөөд үүнээс болж хаан ихэд хилэгнэж Даниелын гурван найзыг халуун зууханд хийж шийтгэхээр болжээ. Их Эзэн тэднийг хамгаалж тэд галд шатсангүй. Халуун зуухан дотор дөрвөн хүн байхыг хаан харав. Гал дотор Есүс тэдэнтэй хамт байсан. Тэгээд хаан хөвгүүдийг чөлөөлжээ.

### Энэ бол магтаал хүндлэлийн тухай хичээл

Даниелын гурван найз хаан болон ард түмний өмнө баттай зогсохоор шийджээ. Ямар нэгэн нөхцөл байдлын зөв талд нь баттай зогсож байгаа нь Их Эзэнийг хүндлэж буй хэрэг юм.

### Багшийн Баяжуулалт

"Хүн төрөлхтний хүч чадлын бэлэг тэмдэг болсон хиймэл шүтээнүүдэд бүх хүмүүс мөргөчихөөгүй байна. Янз

# ДОЛОО

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
<b>Мэндчилгээ</b>	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
<b>1</b> <b>Бэлтгэх Ажил</b>	10 минут	<i>А. Хөгжмийн Дуулгавартай Байдал</i> <i>Б. Елентийн Сорил</i>	хуурцаг тоглуулагч, бичлэгтэй хуурцаг шилтэй ус, галын зураг, хийлсэн бөмбөлөг
<b>*</b> <b>Залбирал ба Магтаал*</b>	10 минут	73-р хуудсыг үз. <b>*Залбирал ба Магтаал</b> -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
<b>2</b> <b>Библийн Хичээл</b>	20 минут	Түүхтэй Танилцах	тоглоомон хөгжмийн зэмсэг
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
<b>3</b> <b>Хичээлээ</b>	15 минут	<i>Багш Хэлэхдээ</i>	байхгүй
<b>4</b> <b>Хичээлээ Хуваалцах нь</b>	15 минут	<i>Халуун Зуух</i>	зуухны загвар (143-р хуудас) цаас, жижиг жүрж, улаан шар целлофаны хэсэг, өнгийн харандаа, цавуу

бүрийн шүтээн шүтдэг хүмүүсийн дунд Их Эзэнийг шүтэхээр шийдсэн гурван залуу байжээ. Тэдний Эзэн бол Дээдийн Дээд, Хаадын Хаан учир тэд өөр ямар ч шүтээнд мөргөхгүй". (Зөнчид ба Хаад, х. 506).

"Еврейчүүд Их Эзэний хүч чадалд бат итгэн, зөвхөн Түүнийг хүндэлдэг байлаа. Бөхийн ёслох гэдэг бол хаанаас нь ч харсан ямар нэгэн зүйлд хүндэтгэл үзүүлж буй хэрэг. Зөвхөн Их Эзэнд үзүүлэх ямар их хүндэтгэл вэ?" (Зөнчид ба Хаад, х. 507).

"Гэвч Их Эзэн Өөрийн хүмүүсээ хэзээ ч мартаагүй. Зууханд болсон үйл

явдал, Аврагч маань Өөрийгөө хүмүүст хүн төрхөөр илчилсэн, галын дунд хамт алхсан зэрэг нь үүнийг гэрчлэх юм. Их Эзэний байсан газар халуун хүйтэн зүйл ч илчээ алдсан нь гайхалтай". (Зөнчид ба Хаад, х. 508, 509).

## Өрөөний Зохион Байгуулалт

Тавдугаар хичээлийг хар. Гуравдугаар хичээл дээр хэрэглэгдсэн "агуй" дээр хар бүтээлэг сандал дээр бүтээж "халуун зуух" хийж болно.

# Заах Хичээл

## Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.



## Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

### А. Хөгжмийн Дуулгавартай Байдал

#### Хэрэгтэй зүйлс:

- хуурцаг тоглуулагч
- бичлэгтэй хуурцаг

Хүүхдүүд нуруу нуруугаа харуулан суухаар сандлуудыг янзалж үе бүрт нэг сандал хасаарай. (Хэрвээ танд урт том сандал байвал, дээр нь хэдэн хүн суухад зориулсныг цаасаар тэмдэглэнэ). Хэлэх: **Одоо бид хөгжимд тохируулан тоглоом тоглохдоо эсрэгээр нь тоглоно. Хөгжим явж байгаад зогсох үед та нар сандлыг тойрон алхах бөгөөд хөгжим эхлэх үед суудалд сууна.** Нэг хүүхэд суудалгүй хоцорч бусад нь бүгд суусан байвал нэг сандал мөн суудалгүй хоцорсон хүүхдийг тоглоомноос гаргана. Үүнийг хэд хэдэн удаа тоглох ба хүүхдүүд бие биенийгээ түлхэж чихэлдэх үед тэдэнд бүү сануул.

#### Багатгах нь

Хүүхдүүдийн хариулыг сонсоорой: **Хөгжим эхлэх үед суудалгүй хоцрох ямар байна? Чи хэн нэгнийг түлхэж чихэлдэхийг хүссэн гэж үү? Энэ нь тийм сайхан байсан гэж үү? Харин яавал дээр байх байсан бэ? Хэн нэгэн буруу зүйл хийж байлаа ч гэсэн тэднийг түлхэж чихэлдэх нь муу хэрэг юм.**

Өнөөдрийн үзэх Библийн түүх бол хөгжим эхлэх үед түүнд мөргөж сөгдөөгүй гурван залуугийн тухай бөгөөд тэр гурван залуу бусад хүмүүс буруу зүйл хийж байсан ч зөв сонголт хийсэн юм. Өнөөдрийн гол санаа:



**Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.**

Намайг дагаад хэлээрэй.

### Б. Ерөнхий Сорил

#### Хэрэгтэй зүйлс:

- шилтэй ус
- галын зураг
- хийлсэн бөмбөлөг

Юуны өмнө, хүүхдүүдэд харагдахаар газар хийлсэн бөмбөлөг, галын зураг, шилтэй усыг байрлуулан тавь. Хэлэх: **Бид одоо таавар тоглоом тоглох гэж байна. Хариулт нь гадаа байгаа бөгөөд анги дотор ч байгаа. Би та нараар таавар таалгана, харин та нар анги дотуур явж миний таалгасан тааврыг таахыг оролдоорой. Хэрвээ чи таалгасан зүйлийн минь хажууд очвол би та нарт "Халуун" гэж хэлэх бөгөөд хэрвээ миний таалгасан зүйлээс хол зогссон байвал би та нарт "Хүйтэн" гэж хэлнэ. Халуун эсвэл хүйтэн гэж хэлэхийнхээ өмнө хүүхдийн нэрийг дуудан хэлнэ.**

Би бол нойтон, бас та нарыг цангасан үед хэрэг болдог. Та нар миний дотор сэлдэг бөгөөд тоглодог. (Ус)

Би бол улаан өнгөтэй, заримдаа цэнхэр, шар, цагаан өнгөтэй байдаг. Би та нарыг дулаацуулдаг, бас та нарыг түлж чаддаг. (Гал)

Би харагддаггүй бөгөөд зөвхөн мэдрэгддэг, өвөл би хүйтэн байдаг ба зуны үед халуун байдаг. Би моддын навчсыг хөдөлгөдөг ба шаарыг хөөргөж чаддаг. (Агаар эсвэл салхи)

### **Бататгах нь**

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: Энэ бүхнийг хэн хийснийг та нар мэдэх үү? Тийм ээ, Их Эзэн л хийсэн юм. Тийм ч учраас бид Түүнийг магтан хүндэлдэг юм. Тэр бүх л дэлхий ертөнцийг бүтээсэн юм. Иймээс, Тэр Цорын Ганц бөгөөд бид Түүнийг магтахыг хүсдэг.

Өнөөдрийн Библийн түүх нь хөшөөнд мөргөхөөс татгалзаж зөв сонголт хийсэн гурван залуугийн тухай юм. Өнөөдрийн гол санаа бол:



**Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.**

Намайг дагаад хэлээрэй.

## **ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ**



### **Нөхөрлөл**

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

### **Санал Болгох Дуунууд**

"Хөгжимдөх нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 220*)

"Их Эзэнийг магтацгаая" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 211*)

"Зөв сонголт хийхэд минь Есүс тусалдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 304*)

"Бяцхан хүү минь, болгоомжтой бай" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 307*)

"Гуниглах ба баярлах" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 271*)

### **Зорилго**

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс нэгэн түүх уншиж өгөөрэй.

### **Хандив**

Хэлэх: **Бид Их Эзэнд өргөлөө өгснөөрөө Түүнийг хүндэлж байдаг.**

### **Залбирал**

Хүмүүс Их Эзэнтэй ярихдаа олон янзын хэлбэрээр залбирдаг. Тэдгээрийг дүрслэн үзүүлээрэй. (Өвдөг сөгдөх, суух, босох гэх мэт). Хэлэх: **Их Эзэнд яаж ч залбирсан бид залбирлаараа Их Эзэнийг хүндэлж байдаг.** Богино хэмжээний залбирал хийгээрэй.

\* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

**Хэрэгтэй зүйлс:**  
 ТОГЛООМОН ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ

*Ангийнхаа хүүхдүүдийг нэг нэг том хүнтэйгээр дөрвөн бүлэг болгон доорх зүйлийг даалгавар болгон өгөөд түүхийг ярихаасаа өмнө давтах цаг олгоорой.*

<b>Та:</b>	<b>Хүүхдүүд:</b>
<b>Хаан эсвэл Небухаднезар Цэргүүд</b>	"Өө, үгүй ээ"
<b>Хөгжим</b>	Нэг эгнээнд жагсаж "Тип Тап"
<b>Гал</b>	Хөгжим тоглож буй мэт дүр эсгэх
	"Сссс" гэж хэлнэ.
	Түүхийг эхлэхээсээ өмнө давтаарай.

**Түүхийг унших эсвэл ярьж өгөх**  
**Небухаднезар хаан [Өө, үгүй ээ]** өөрөөрөө ихэд бахархан байв. Түүний бариулсан асар том алтан хөшөө нь хүн бүрийн нүдэнд ил газар баригдаад дуусчээ. Тэрээр улсынхаа бүхий л чухал гэсэн хүмүүсээ урьсан нь тэр том агуу хөшөөг хараад өөрийг нь агуу **хаан [Өө, үгүй ээ]** гэж бодох байх гэж бодсоных нь юм.

Дараагийн өглөө нь Шадрах, Мешах, Абед-него болон бусад чухал хүмүүс **хааны [Өө, үгүй ээ]** хөшөөг харахаар ирээд бүгд л хөшөөг харан гайхширан зогсоно. Шадрах, Мешах, Абед-него болон бусад хүмүүс хөшөөний хажуу дахь том хар агуй шиг байшин луу харан гайхна. **Цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх]** энэ том байшингийн дотор нэлээн их гал асаажээ.

"**Цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх]** яагаад үүнийг хийж байгаа вэ? хэмээн Шадрах, Мешах, Абед-него нар хоорондоо шивнэлдэнэ.

**Небухаднезар хааныг [Өө, үгүй ээ]** дохио өгөх үед **хөгжим [хөгжим**

*тоглож буй дүр эсгэх]* тоглогдоход бэлэн байлаа. Эцэст нь, **хааны [Өө, үгүй ээ]** **цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх]** цугласан олны өмнө зогсоод "**Небухаднезар хааны [Өө, үгүй ээ]** зарлигийг сонсоно уу. **Хөгжим [хөгжим тоглож буй дүр эсгэх]** дуу гарахад та бүгд алтан хөшөөнд бөхийн ёслож хүндэтгэл үзүүлэх ёстой. Үүнийг мөрдөөгүй хэнийг ч **галд [Ссссс]** хийх болно" гэж чанга дуугаар хэлэв.

Гэнэт **хөгжим [хөгжим тоглож буй дүр эсгэх]** дуу гарч цугласан хүмүүс бүгд **хааны [Өө, үгүй ээ]** хөшөөнд мөргөв. Шадрах, Мешах, Абед-него гэх Даниелын гурван сайн найзаас бусад бүх хүмүүс. Тэд зөвхөн Их Эзэнийг л хүндлэн мөргөдөг. Тэд **хааны [Өө, үгүй ээ]** хөшөөнд хэзээ ч мөргөж чадахгүй.

Зарим **цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх]** болон мэргэдүүд **хаанд [Өө, үгүй ээ]** яаравчлан ирж энэ тухай мэдэгдээд "Та **хөгжим [хөгжим тоглож буй дүр эсгэх]** дуу гарч эхлэхэд бүх хүн энэ хөшөөнд бөхийн ёслохгүй бол ёслоогүй хүнийг **галд [Ссссс]** хийнэ гэсэн билээ. Хар л даа, Шадрах, Мешах, Абед-него нар мөргөсөнгүй" гэв.

**Небухаднезар хааны [Өө, үгүй ээ]** царай улайн ихэд хилэгнэн "Тэр гурвыг над дээр авчир" хэмээн тушаал буулгав. **Цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх]** Шадрах, Мешах, Абед-него нарыг **хаанд [Өө, үгүй ээ]** авчирч өгөхөөр явлаа.

"Шадрах, Мешах, Абед-него та нар алтан хөшөөнд бөхийн ёслохоос татагалзсан гэж үнэн үү?" гэж **хаан [Өө, үгүй ээ]** асуухад тэд "Тийм" гэжээ.

"Би та нарт дахин нэг боломж өгье. Хэрвээ та нар алтан хөшөөнд бөхийн ёслож хүндэтгэл үзүүлэхгүй бол галд шидэгдэх болно шүү дээ" гэж **хаан [Өө, үгүй ээ]** хэллээ.

Шадрах, Мешах, Абед-него нар хааны [Өө, үгүй ээ] өмнө эгц зогсоод "Та биднийг галдаа шидэгтүн. Бидний Их Эзэн биднийг хамгаалах болно. Тэр биднийг аврахгүй байсан ч бид алтан хөшөөнд хүндэтгэл үзүүлэхгүй" гэв.

"Галыг [Ссссс] долоо дахин ихэсгэ. Тэднийг хүлээд галд [Ссссс] хий" гэж хаан [Өө, үгүй ээ] цэргүүдэд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх] тушаав.

Тэгээд цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх] Шадрах, Мешах, Абед-него нарыг хүлэн хаан [Өө, үгүй ээ] болон бүх хүмүүс харж байхад галд [Ссссс] шидэв.

Цэргүүд [эгц зосож маршаар алхан "Тип Тап" гэх] тэр гурвыг зууханд хийх үед гал маш их халуунаар шатаж байлаа.

Небухаднезар хаан [Өө, үгүй ээ] гал [Ссссс] тэр гурвыг сайн болгож өгнө дөө гэсэн бодлоор зуух руу өнгийгөөд "Бид гурван залууг хүлж хийсэн биз дээ. Тэнд дөрөв байх юм. Тэгээд дөрөв дэх нь яг л Их Эзэний Хүү шиг харагдаж байна" гэж орилжээ.

Небухаднезар хаан [Өө, үгүй ээ] зууханд чадахаараа ойртон "Шадрах, Мешах, Абед-него, та нар гараад ир" гэв.

Шадрах, Мешах, Абед-него нар галаас гарч ирэхэд тойрон зогссон хүмүүс үсийг нь барьж арьсийг нь тэмтэрч хувцсыг нь шалгаж үзээд үнэхээр их гайхлаа. Учир нь тэдний үс шатаагүй, арьс нь гэмтээгүй, хувцас нь бүтэн байсан бөгөөд тэднээс утаа ч үнэртэхгүй байжээ.

"Шадрах, Мешах, Абед-него нарын Их Эзэнийг магтацгаая. Тэдний Их Эзэн үйлчлэгч нараа галаас [Ссссс] аварчээ. Өөр ямар ч шүтээн ийм зүйл хийж үл чадна" гэж Небухаднезар хаан [Өө, үгүй ээ] хэллээ.

#### Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: Шадрах, Мешах, Абед-него нартай хамт хэн галд байсан

бэ? Тэднийг Есүс галаас аврахад тэдэнд ямар байсан гэж бодож байна? Тэд Их Эзэнийг магтмаар санагдсан байх, тийм биш гэж үү? Гэвч тэд аль хэдийн Их Эзэнийг магтаж хүндэлсэн байлаа. Та нар яасныг нь мэдэх үү? Тэд Небухаднезар хааны хөшөөнд мөргөхийг татгалзсанаараа Их Эзэнийг хүндэлсэн юм. Тэд буруу зүйл хийхээс татгалзсан юм.



Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

#### Библи Судлал

Библиэ нээгээд Даниел 3-г гарган "Бидний өнөөдрийн үзсэн түүх Бурханы үг болсон Библийн энэ хэсэгт бичигдсэн байдаг юм" гэж хэлээд сэдвийг чангаар уншаарай. Шаардлагатай бол өөрийн үгээр энгийн ойлгомжтой болгож уншаарай.

#### Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: Хааны хөшөө юугаар хийгдсэн бэ? Хөгжим эхлэх үед хаан хүмүүсийг юу хийхийг хүссэн бэ? Хааны үгэнд хэн ороогүй вэ? Яагаад? Шадрах, Мешах, Абед-него нарыг хаан яасан бэ?

Гурван залууг галд байхад юу болсон бэ? Тэдэнтэй хамт хэн байсан бэ?

Буруу зүйлд татгалзах үед Есүс та нартай хамт байх болов уу? Тийм ээ, Түүний үгийг дагаж Түүнийг хүндэтгэвэл Есүс үргэлж та нартай хамт байх болно. Санагтун:



Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

Хэрэгтэй зүйлс:

Библи

**Цээжлэх Ишлэл**

**Хэрэгтэй зүйлс:**  
□ Библи

Иошуа 24:15-г гаргаад Библиэ хүүхдүүдэд харагдахаар өндөрт өргөж бариарай.

"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна" гэж хэлээд сэдвийг чангаар унш. "Бид Их Эзэнд үйлчлэх болно". Цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.



**Бид**

Өөрийгөө заагаад бусдыг заах.



**Их Эзэнд**

Дээшээ заах.



**үйлчлэх болно.**

Алгаа дэлгэн гараа цээжнээсээ урагш нь буулгах.



**Иошуа 24:15**

Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

**3**

**Хичээлээ Заах**

**Багш Хэлэхдээ**

Хэлэх: Бид одоо "Багш хэлэхдээ" гэсэн тоглоом тоглоно. Би та нарт хийхэд буруу бас зөв зүйлүүдийг хийхийг хэлнэ.

Та нарыг зөв зүйл хийхийг хүсэж байгаа гэж би мэдэж байгаа учраас анхааралтай сонсоорой. Намайг хийхэд зөв зүйл хэлбэл та нар нэг алхам урагшлах бөгөөд хийхэд буруу зүйл хэлвэл та нар нэг алхам ухрах ёстой.

Хийхэд буруу зүйл хэлэхдээ "Багш хэлэхдээ" гэж хэлэх бөгөөд хийхэд зөв зүйл хэлэхдээ "Багш хэлэхдээ" гэж хэлэхгүй байх ба энэ нь хүүхдүүдийг гурван еврей залуу хааны үгийг дагалгүй хэрхэн Их Эзэнийг хүндэлсэн гэдгийг ойлгоход тус болно. Хэлэх:

- Эмээгээ тэвэр.
- Багш хэлэхдээ, ахыгаа цохь.
- Багш хэлэхдээ, ээжтэйгээ хэрэлд.
- Ээждээ бэлэг өг.
- Багш хэлэхдээ, хэн нэгний тоглоомыг эвд.
- Тоглоомоо хуваалц.

Өрөөгөө цэвэрлэ.

Багш хэлэхдээ, аавынхаа үгэнд бүү ор.

Цээжлэх ишлэлээ давт.

Багш хэлэхдээ, эгчтэйгээ муудалц.

**Бататгах нь**

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой. **Багшийн хэлсэн зүйлийг хийх гэж бодохоор та нарт хэцүү байсан уу?** (Яагаад гэвэл буруу зүйл байсан юм.) **Та нарыг хэн нэгэн муу зүйл хий гэж хэлж байсан уу? Та нар тэгэхэд юу хийсэн бэ? Юу хийх гэж байгаагаа мэдэхэд та нарт хэцүү байсан уу?**

Үгүй гэж хэлэх эсвэл бусдаас өөр байх нь эвгүй байдаг ч бид Их Эзэний үгийг Шадрах, Мешах, Абед-него нар шиг дагахыг хүсдэг. Одоо бүгдээрээ гол утга санаагаа санацгаая:



**Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.**

Намайг дагаад хэлээрэй.

4

**Хичээлээ Хуваалцах нь**

**“Хөршөө Хайрла” Өргөө**

Юуны өмнө, хүүхэд бүрт зуухны загвар зургийг (143-р хуудас) хувилж өгөөд ариун цэврийн цаасыг жижиг жижиг хэсэгт хуваа. Хүүхдүүдээр зургийг будуулан жижиг хэсэг болгосон цаасаа дээр нь наалгаарай. Тэгвэл яг зуухан дотор гал шатаж байгаа мэт харагдана. Асуух нь: **Халуун зуух дээр юу бичсэнийг та нар мэдэх үү? Санагтун.**



**Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.**

Намайг дагаад хэлээрэй.

**Багатгах нь**

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Буруу зүйл хийхээсээ татгалзахад үргэлж амархан байдаг уу? Шадрах, Мешах, Абед-него нарт хэн тусалсан бэ? Чамд хэн туслах вэ?**

**Халуун зуухны зургаа гэртээ авч яваад хэн нэгэнтэй хуваалцаж түүнд хиймэл хөшөөнд мөргөхөөс татгалзсан гурван залуугийн тухай ярьж өгөөрэй. Санагтун:**



**Бурууд татгалзсанаараа бид Их Эзэнийг хүндэтгэдэг.**

Намайг дагаад хэлээрэй.

**Хэрэгтэй зүйлс:**

- халуун зуухны загвар (143-р хуудас)
- цаас
- улбар шар, улаан, шар өнгийн ариун цэврийн цаас эсвэл целлофан
- өнгийн харандаа
- цавуу

**Хичээлийн Хаалт**

Хүүхдүүд Их Эзэнийг хүндэлдэг учир тэднийг буруу зүйлд үгүй гэж хэлж чаддаг байхын төлөө Их Эзэнээс гуйн залбираарай.



## Галтай Зуух

### Унших Зүйл

Даниел 3;  
Зөнчид ба Хаад,  
х. 503-513.

### Цээжлэх Ишлэл

"Бид Их Эзэнд  
үйлчлэх болно"  
(Иошуа 24:15).

### Гол Санаа

**Бурууд  
татгалзсанаараа  
бид Их Эзэнийг  
хүндэтгэдэг.**

*Хэн нэгэн танаар муу зүйл хийлгэхийг хүсэж байсан уу? Тэр үед та яасан бэ? Шадрах, Мешах, Абед-него нарыг ч мөн муу зүйл хийхийг шаардсан юм.*

Найман давхар байртай тэнцэх өндөртэй маш том алтан хөшөө хааны тушаалаар сая нэг юм баригдаж дууслаа. Дараагийн өдөр нь Небухаднезарт үйлчилдэг бүх л захирагчид хотод цуглан агуу том алтан хөшөөг гайхан харлаа.

Захирагчид мөн түүний хажууд буй том байшин дотор цэргүүд гал түлж байгааг хараад "Эд нар юу хийж байна вэ?" гэж шивнэлдэнэ.

Эцэст нь цугласан олны өмнө зогсож буй нэгэн "Хүмүүс ээ, хааны зарлигийг сонсогтун. Хөгжимчид хөгжимдөж эхлэх үед та бүхэн хааны алтан хөшөөнд мөргөн хүндэтгэл үзүүлэх ёстой. Эс тэгвээс галтай зууханд шидэх болно" гэж чанга дуугаар хашгирав.

Гэнэт хөгжим дуугарч бүгд бөхийн сөгдлөө. Даниелын гурван найз Шадрах, Мешах, Абед-него нараас бусад хүмүүс сөгдсөн байв. Даниелын гурван найз Еврей бөгөөд Их Эзэний сонгосон хүмүүс юм. Тэд зүгээр л нэг хөшөө барималд сөгдөж чадахгүй. Зарим хүн тэднийг хараад хаанд ирж "Хараач, тэр гурван Еврей мөргөсөнгүй" гэж хэлэв. Небухаднезар хаан ихэд хилэгнэн ууртай ширүүнээр "Тэднийг авчир" гэж тушаал буулгаад авчирсаных нь дараа "Та гурав алтан хөшөөнд мөргөхөөс татгалзсан гэсэн үнэн үү? Би та нарт дахин нэг боломж өгье. Хэрвээ та гурав одоо алтан

хөшөөнд мөргөхөөс дахин татгалзвал би та гурвыг галд шидэх болно. Тэгээд та нарт хэн тусална гэж?" гэхэд Шадрах, Мешах, Абед-него нар "Өө, хаантан минь. Бидний Их Эзэн биднийг хамгаалах болно. Тэр биднийг аврахгүй байлаа ч бид алтан хөшөөнд мөргөхгүй" гэжээ.

"Галыг долоо дахин ихэсгэж тэднийг хүлээд шидэгтүн" хэмээн Небухаднезар хаан ихэд ууртайгаар цэргүүдэд тушаав. Тэгээд цэргүүд Шадрах, Мешах, Абед-него нарыг тушаал ёсоор улалзсан галтай зууханд шидлээ.

Небухаднезар хаан зуух руу хараад "Бид гурван залууг хүлж хийсэн биз дээ?"

Би дөрвийг харлаа. Дөрөв дэх нь яг л Их Эзэний хүү шиг харагдаж байна" гэж уулга алдав.

"Шадрах, Мешах, Абед-него гараад ир" гэж хааныг дуудахад тэд галаас гарч иржээ. Захирагчид ч тэднийг үзэхээр тойрон зогсов. Цугласан олон итгэж ч чадахгүй байв. Учир нь гурван залуу огтхон ч түлэгдээгүй байв. Тэднээс бүр хиншүү ч үнэртэхгүй байсан гээч.

"Шадрах, Мешах, Абед-него нарын Их Эзэнийг магтагтун" гэж хаан хашгирав. "Тэдний Бурхан Эзэн Өөрийн боолуудаа галаас аварлаа.

Өөр ямар ч шүтээн ийм зүйл хийж үл чадна" хэмээн хаан хэллээ.



# Дасгал Ажил

## Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

- Бид** .....Өөрийгөө заагаад бусдыг заах.  
**Их Эзэнд** .....Дээшээ заах.  
**үйлчлэх болно**.....Алгаа дэлгэн гараа цээжнээсээ урагш нь эгц барих.  
**Иошуа 24:15**.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## Ням

Шаббат хичээл дээр хийсэн зуухны зургаа хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Библийн түүхийг ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл зуухны зураг зурж будаж болно.)

## Даваа

Өндөг хийдэг сав аваад хүүхэдтэйгээ хамт гадагшаа гарч Их Эзэний бүтээсэн зүйлүүдийг дотор нь хийгээрэй. (Нүх бүрт нэг зүйл). Зөвхөн Их Эзэн л энэ бүгдийг бүтээсэн ба Тэр л зөвхөн бидний магтаалыг хүлээн авдаг талаар ярилцаарай.

## Мягмар

Галын аюулгүй байдлын талаар хүүхэдтэйгээ ярилцаж "Найз чинь галаар тоглохыг хүсвэл энэ нь буруу юм. (Яагаад гэдгийг нь хэлж өг.) Бид буруу зүйл хийхээс татгалзаж Их Эзэнийг

хүндлэж байдаг" гэж хэлээд асуух нь: Есүсийн төлөө чи бас зоригтой байхыг хүсэж байна уу?

## Лхагва

Лаа асааж галын шатах дулааны хэмжээнээс шалтгаалж галын өнгө өөрчлөгддөг талаар тайлбарлаж өг. Лаа болон шүдэнз хэрэглэхдээ хэрхэн аюулгүй байх тухай ярилцаарай.

Гал командад очих эсвэл галын тухай ном уншвал хүүхэд тань яагаад тэр еврейчүүд галаас зугтаасныг ойлгоход тустай.

## Пүрэв

Гэрээ тойрон хөгжмийн аянд алхаж байгаад таныг хөгжимөө зогсоох үед хүүхэд тань хөдөлгөөнгүй болох ёстой. Тэгээд хөгжим дахин эхлэх үед алхаж эхэлнэ. Шадрах, Мешах, Абед-него нар хөгжим дуугарч эхлэхэд хөшөөнд мөргөхөөр шаардагдсан гэдгийг хүүхдэдээ сануулаад буруу зүйлд хэрхэн татгалзаж байсан тухайгаа хүүхдэдээ ярьж өг. Тэгээд юу болсон бэ? Хүүхэд тань буруу зүйлд үгүй гэж хэлдэг байхын төлөө гуйгаарай.

## Баасан

Гэр бүлийнхээ оройн залбирлын үеэр хүүхдээрээ Библийн түүхийг яриулж ямар нэгэн хөгжмийн зэмсэг ашиглан дуу дуулаарай. Гэр бүлийнхэн тань Их Эзэнд үйлчилдэг байхын төлөө гуйгаарай.

